



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны эхний
хагас жилийн санхүүгийн тайлангийн тухай

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4-р хавсралтын 3.1.4-р заалт болон тус компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны 08-р сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гермес Центр” ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь үнэн зөв толилуулагдсан болохыг баталсугай.
2. Хөндлөнгийн аудитын байгууллагаас ирүүлсэн заавар, зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Компанийн эхний хагас жилийн санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн ээлжит хуралд танилцуулж, батлуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Д.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

Аудитын хорооны дарга:

Гишүүд:



Д.ТУЯА

Н.БАТСАЙХАН

Б.АЛТАНГЭРЭЛ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20²³ оны 08 сарын 23 өдөр

Дугаар 6

Улаанбаатар хот

Санхүүгийн
тайланг батлах тухай

Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 08-р сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр” ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайланг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан санхүүгийн тайланд дурьдагдсан аудитын байгууллагын санамж, зөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК

Бүртгэл хяналтын итгэмжлэгдсэн байгууллага

№ 23/150

Улаанбаатар хот
СБД, Цэцээ гүн 206 тоот өрөө
Утас: 99096584

“Гермес центр” ХК
Захирал Б.Оюунцэцэг танаа

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу “Гермес центр” ХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 30-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт:

Бидний дүгнэлтээр “Гермес центр” ХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 30-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

АОУС-ын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд:

Бидний шалгасан тайланд анхаарал татах аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл:

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний

дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэж танилцуулах нь байгууллагын гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага юм.

Энэхүү санхүүгийн тайлангуудыг залилан болон алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг бий болгох, тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв, бодитой бэлтгэгдсэн эсэхийн хариуцлагыг байгууллагын удирдлага хүлээнэ.


Аудиторын хүлээх хариуцлага:

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит батапгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтээр өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэж итгэж байгаач АОУС-ын дагуу хийж гүйцэтгэж байгаа аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш.

Хүндэтгэсэн

ЗАХИРАЛ



М.СЭВЖИДМАА

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"Гермес центр" ХК
(Байгууллагын нэр)

СТА/2023/150

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 06 сарын 30	Тайлант оноос /+өссөн/ / -буурсан / үзүүлэлт
А.ХӨРӨНГӨ			
1. Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,604,423,570.74	3,118,189,615.36	513,766,044.62
Дансны авлага	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага	-	-	-
Бусад авлага	73,107,157.50	70,000,000.00	(3,107,157.50)
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-
Бараа материал	6,187,363.73	8,491,691.02	2,304,327.29
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	-	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,683,718,091.97	3,196,681,306.38	512,963,214.41
2. Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	3,770,561,008.83	3,688,949,564.00	(81,611,444.83)
Биет бус хөрөнгө	2,288,496,000.00	2,288,496,000.00	-
Биологийн хөрөнгө	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Дуусаагүй барилга	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,059,057,008.83	5,977,445,564.00	(81,611,444.83)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,742,775,100.80	9,174,126,870.38	431,351,769.58
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
3. Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	-	-	-
Цалингийн өглөг	-	-	-
Татварын өр	71,848,608.90	99,216,027.49	27,367,418.59
Бусад богино хугацаат өр төлбөр	205,226,414.92	252,608,996.35	47,382,581.43
Богино хугацаат өр төлбөрийн дүн	285,321,309.41	361,919,403.16	76,598,093.75
4. Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-	-
Өр төлбөрийн нийт дүн	285,321,309.41	361,919,403.16	76,598,093.75
5. Эзэмшигчийн өмч			
Өмч: - төрийн	-	-	-
- хувийн	7,854,300,100.00	7,854,300,100.00	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг	603,153,691.39	957,907,367.22	354,753,675.83
Эзэмшигчийн өмчийн дүн	8,457,453,791.39	8,812,207,467.22	354,753,675.83
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,742,775,100.80	9,174,126,870.38	431,351,769.58

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Цэвэр борлуулалт	2,059,006,005.73	1,255,867,588.14	(803,138,417.59)
Борлуулалтын өртөг	-	-	-
Нийт ашиг (алдагдал)	2,059,006,005.73	1,255,867,588.14	(803,138,417.59)
Түрээсийн орлого	-	-	-
Хүүний орлого	240,483,687.71	269,111,211.71	28,627,524.00
Бусад орлого	236,000.00	27,000.00	(209,000.00)
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	916,331,917.70	460,663,965.10	(455,667,952.60)
Санхүүгийн зардал	-	-	-
Бусад зардал	-	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	14,161.24	(284.06)	(14,445.30)
Биег бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,383,407,936.98	1,064,341,550.69	(319,066,386.29)
Орлогын албан татварын зардал	138,339,377.57	106,434,183.48	(31,905,194.09)
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	1,245,068,559.41	957,907,367.21	(287,161,192.20)
Цэвэр ашиг (алдагдал)	1,245,068,559.41	957,907,367.21	(287,161,192.20)
Орлогын нийт дүн	1,245,068,559.41	957,907,367.21	(287,161,192.20)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмч	7,854,300,100.00	7,854,300,100.00	-
Халаасны хувьцаа	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг /- алдагдал/	603,153,691.39	957,907,367.21	354,753,675.82
Нийт дүн	8,457,453,791.39	8,812,207,467.21	354,753,675.82


МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	2,315,409,179.08	1,417,420,417.02	(897,988,762.06)
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,233,687,399.06	1,366,644,008.66	(867,043,390.40)
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	-
Будаан авсан албан татвар	-	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	81,721,780.02	50,776,408.36	(30,945,371.66)
Мөнгөн зарлагын дүн (-)	1,194,621,648.38	617,720,912.09	(576,900,736.29)
Ажиллагчдад төлсөн	288,035,490.00	161,916,695.00	(126,118,795.00)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	76,740,962.00	41,898,306.00	(34,842,656.00)
Бараа материал худалдан авахад төлсөн	44,089,999.45	11,540,020.00	(32,549,979.45)
Ашиглалтын зардалд төлсөн	148,015,095.24	83,438,396.99	(64,576,698.25)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	305,800.00	878,200.00	572,400.00
Хүүний төлбөрт төлсөн	-	-	-
Татварын байгууллагад төлсөн	469,558,641.21	272,303,322.98	(197,255,318.23)
Даатгалын төлбөрт төлсөн	-	-	-
Бусад мөнгөн зарлага	167,875,660.48	45,745,971.12	(122,129,689.36)

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,120,787,530.70	799,699,504.93	(321,088,025.77)
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн (+)	240,483,687.71	269,111,211.71	28,627,524.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-	-
Хүлээн авсан хүүний орлого	240,483,687.71	269,111,211.71	28,627,524.00
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	4,030,900.00	-	(4,030,900.00)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,030,900.00	-	(4,030,900.00)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	236,452,787.71	269,111,211.71	32,658,424.00
3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн (+)	250,161.24	26,715.94	(223,445.30)
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	-
Төрөл бүрийн хандив	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэл	250,161.24	26,715.94	(223,445.30)
Мөнгөн зарлагын дүн (-)	1,063,073,044.68	555,071,387.96	(508,001,656.72)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-	-
Төлсөн ногдол тэгшитгэл	1,063,073,044.68	555,071,387.96	(508,001,656.72)
Валютын ханшийн зөрүү	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,062,822,883.44)	(555,044,672.02)	507,778,211.42
Валютын ханшийн зөрүү	-	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	294,417,434.97	513,766,044.62	219,348,609.65
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,310,006,135.77	2,604,423,570.74	294,417,434.97
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,604,423,570.74	3,118,189,615.36	513,766,044.62

Аудитор



Д.Чулуунбат



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20... оны 08 сарын 23 өдөр

Дугаар 7

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 6-р бүлгийн 46-р зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 08-р сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас:
 - 1.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашигт 942 516 012.00 төгрөг (есөн зуун дөчин хоёр сая таван зуун арван зургаан мянга арван хоёр төгрөг 00 мөнгө)-ийг
 - 1.2 Компанийн цалин урамшуулал нөөцийн санд 15 391 355.22 төгрөг (арван таван сая гурван зуун ерөн нэгэн мянга гурван зуун тавин таван төгрөг 22 мөнгө)-ийг тус тус хуваарилсугай.
2. "Гермес центр" ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46-р зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 08-р сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 12 төгрөг (арван хоёр төг 00 мөн)-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 09-р сарын 13-ны өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны эхний хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2023 оны 09-р сарын 18-ны өдрөөс 2023 оны 10-р сарын 20-ны өдрийн дотор компанийн төв байран дээр бэлэн мөнгөөр болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-тэй гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН